



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 89

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчид 5 барилга байгууламж  
бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Койка)-ын буцалтгүй тусламжаар тус тус баригдаж ашиглалтад орсон, нийт 11,980,116,458 (арван нэгэн тэрбум есөн зуун наян сая нэг зуун арван зургаан мянга дөрвөн зуун тавин найм) төгрөгийн өртөг бүхий, хавсралтад дурдсан 5 барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 89.....  
дүгээр тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	Жимс, жимсгэнэ тариалан эрхлэгчдийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилга, байгууламж	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Хар усан тохой, Сод Монгол ШТС-ын урд талд	2021	1,946,890,215	Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Койка)-ын буцалтгүй тусламж
2	44 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилга	Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо, 16 хороолол, 53 дугаар сургуулийн хойд талд	2022	3,941,325,422	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
3	107 дугаар сургуулийн өргөтгөлийн барилга	Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хороо, Нарангийн гол	2019	1,860,800,000	
4	Цагдаагийн газрын 2 дугаар хэлтсийн барилга	Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо, Дамбадаржаа	2017	1,453,361,547	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
5	118 дугаар сургуулийн өргөтгөлийн барилга	Хан-Уул дүүргийн 8 дугаар хороо, Наадамчдын гудамж	2022	2,777,739,274	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
<b>Нийт бүртгэх барилга байгууламжийн дүн</b>				<b>11,980,116,458</b>	